



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 22 өдөр

Дугаар АБ5

Чойр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.1.3, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 61 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 6.9 км /Говьсүмбэр, Шивээговь сум/”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Д.Батцэцэг

(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга)

Гишүүд:

Ч.Сугармаа

(Шивээговь сумын Засаг даргын орлогч дарга)

Ц.Замбага

(Шивээговь сумын Хөрөнгө оруулалт, эдийн засгийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)

Хөндлөнгийн төлөөлөл:

Ө.Наранчулуун

(Сүмбэр сумын 3 дугаар багийн иргэн)

Нарийн бичгийн дарга:

Б.Болд-Эрдэнэ

(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Д.Батцэцэг)-д үүрэг болгосугай.

3.Үнэлгээний хорооны зөвлөмжид үндэслэн шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтаар бий болсон өмч хөрөнгийг бүртгэл, тайланд тусгаж, эзэмшил ашиглалтад хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТЗАМ